



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/62

Амардалай

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в" заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой Байгаль орчинд халгүй микробиологийн аргаар тэмцэх ажилд малчид, мал бүхий иргэд дэмжлэг үзүүлж бактержуулсан будаа цацах 3 мянган га талбайн бэлчээрийг 2021 оны 05 дугаар сарын 11 ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 13 ны өдрийг хүртэл 3 хоногийн хугацаатай чөлөөлсүгэй.

2. Бэлчээр чөлөөлөх хугацаанд хөдөлмөр хамгаалал, хүн амын эрүүл ахуйн шаардлагыг хангах талаарх мэдээ мэдээллийг малчдад хүргэж, малаа хариулга маллагаатай байгаад хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Баянбулаг багт бактержуулсан будааг (Тарлан, Улааннуур, Сүүж, Халгайт), Цахиурт багт бактержуулсан будааг (Моломын ухаа, Хажуу худаг, Хадан хошуу, Хэлтгий) гэсэн газруудад цацаж дууснаас хойш 21 хоногийн хугацаанд малаа бэлчээхгүй байхыг тухайн нутаг дэвсгэрт байгаа малчдад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ